



AI-Д СУУРИЛСАН СИНТЕТИК МЭДЭЭЛЭЛ БА УЛС ТӨРИЙН КОММУНИКАЦИ

Б.Чимэдлхам*, Д.Ундрах**

**МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн магистрант*

*** МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн профессор, доктор (Ph.D.)*

Түлхүүр үгс: синтетик мэдээлэл, deepfake, хиймэл оюун ухаан, улс төрийн коммуникаци, мэдээллийн манипуляци, эрх зүйн зохицуулалт

Оршил. Сүүлийн жилүүдэд хиймэл оюун ухааны (Artificial Intelligence) хурдацтай хөгжил нь мэдээллийн орчныг суурь түвшинд өөрчилж, синтетик мэдээлэл (synthetic media) хэмээх шинэ үзэгдлийг бий болгов. Синтетик мэдээлэл нь алгоритм, өгөгдөлд суурилан бодит мэт харагдах текст, зураг, аудио, видео контентыг үүсгэх боломжтой бөгөөд улс төрийн мэдээлэл, харилцаанд шинэ төрлийн нөлөөллийн механизмыг бий болгож байна (Chesney & Citron, 2019). Ялангуяа deepfake технологи нь бодит хүний дүр төрх, дуу хоолойг өндөр нарийвчлалтай дуурайлган бүтээх боломжийг бүрдүүлж, мэдээллийн үнэн бодит байдлыг ялган таних үйл явцыг хүндрүүлэв. Энэ нь олон нийтийн мэдээлэлд итгэх итгэл, улс төрийн шийдвэр гаргалтад нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна (Vaccari & Chadwick, 2020).

Дижитал орчин, социал медиа платформуудын өргөн хэрэглээ нь синтетик мэдээллийн тархалтыг хурдасгаж, алгоритмд суурилсан контент түгээлтийн системээр дамжуулан өргөн хүрээнд нөлөөлөх боломжийг бий болгож байна. Иймээс синтетик мэдээлэл нь зөвхөн технологийн асуудал бус, харин улс төр, нийгэм, эрх зүйн олон талт асуудлыг хамарсан цогц үзэгдэл болж байна. Энэхүү тойм өгүүллийн зорилго нь хиймэл оюун ухаанд суурилсан синтетик мэдээллийн онолын үндэс, мэдээллийн

манипуляцийн механизм, судлагдсан байдлын тойм, Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг системтэйгээр авч үзэхэд оршино.

Улс төрийн мэдээлэл харилцааны онолын үндэс. Улс төрийн мэдээлэл, харилцаа нь төр, хэвлэл мэдээлэл, олон нийтийн хооронд мэдээлэл үүсэх, түгэх, хүлээн авах үйл явцыг хамарсан цогц ойлголт юм. Энэхүү ойлголтыг тайлбарлахад медиа нөлөөллийн уламжлалт онолууд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн.

Хэлэлцэх асуудлын сэдэв тогтоох онол (agenda-setting) нь (McCombs & Shaw, 1972) хэвлэл мэдээлэл олон нийтийн юу бодохыг бус, харин юунд анхаарахыг тодорхойлдог гэж үздэг. Өөрөөр хэлбэл, тодорхой асуудлыг олон давтамжтайгаар мэдээлснээр тухайн асуудал олон нийтийн хувьд чухалд тооцогдох нөхцөл бүрддэг.

Мэдээллийн хүрээ тогтоох онол (framing) нь (Entman, 1993) нэг үйл явдлыг хэрхэн тайлбарлаж байгаагаас хэрэглэгчдийн ойлголт өөрчлөгдөж болдгийг онцолдог. Нэг ижил мэдээллийг өөр өөр өнцгөөс хүргэх нь улс төрийн байр суурь, үнэлгээнд шууд нөлөөлөх боломжтой.

Урьдчилсан нөлөөллийн онол (priming) нь (Iyengar, 1987) өмнөх мэдээлэл дараагийн мэдээллийг хэрхэн хүлээн авахад нөлөөлдөг болохыг тайлбарладаг. Хэрэглэгчид өмнө нь хүлээн авсан мэдээлэлд тулгуурлан улс төрийн шийдвэр гаргах хандлагатай байдаг.

Гэвч орчин үеийн дижитал орчинд эдгээр онолуудыг дахин авч үзэх шаардлага үүсэж байна. Сошиал медиа платформуудын алгоритм нь хэрэглэгчдэд ямар мэдээлэл хүрэхийг тодорхойлж, мэдээллийн урсгалыг зохицуулах болсон. Энэ үзэгдлийг алгоритмд суурилсан харилцаа (algorithmic communication) (Klinger, 2018) гэж тодорхойлдог. Мөн хиймэл оюун ухаанд суурилсан синтетик контент давамгайлсан орчныг хиймэл мэдээллийн орчин (synthetic information environment) гэж үзэх болсон. Энэ нь мэдээлэл зөвхөн дамжуулагдах бус, харин хиймлээр үүсгэгддэг шинэ нөхцөл байдлыг илэрхийлж байна.

Иймээс улс төрийн мэдээлэл, харилцааны уламжлалт онолуудыг алгоритм, хиймэл оюун ухааны орчинд шинэчлэн тайлбарлах шаардлага үүсэж байна.

Синтетик мэдээлэл ба мэдээллийн манипуляци. Хиймэл оюун ухаанд суурилсан синтетик мэдээлэл (synthetic media) нь алгоритм, өгөгдөлд суурилан үүсгэсэн боловч бодит мэт харагдах контентыг илэрхийлдэг. Энэ нь текст, зураг, аудио, видео зэрэг олон хэлбэртэй байж болох бөгөөд ялангуяа deepfake технологи нь хүний дүр төрх, дуу хоолойг өндөр нарийвчлалтайгаар дуурайлган бүтээх боломжийг олгодог.

Синтетик мэдээллийн онцлог нь түүний “итгэл төрүүлэх чадвар”-т оршдог. Уламжлалт худал мэдээлэл нь логик зөрчил, эх сурвалжийн тодорхойгүй байдлаар илэрдэг бол синтетик мэдээлэл нь визуал болон аудио бодит байдлыг дуурайлган хэрэглэгчдэд үнэн мэт сэтгэгдэл төрүүлдэг. Энэ нь мэдээллийн үнэн бодит байдлыг ялган таних үйл явцыг хүндрүүлж, хэрэглэгчдийн шүүмжлэлтэй сэтгэлгээг сулруулах эрсдэлтэй.

Мэдээллийн манипуляцийн онолын хүрээнд misinformation (санаандгүй буруу мэдээлэл), disinformation (санаатай худал мэдээлэл), malinformation (үнэн боловч хор нөлөөтэй мэдээлэл) гэсэн ангилал өргөн хэрэглэгддэг. Гэвч синтетик мэдээлэл нь эдгээр ойлголтыг өргөжүүлж, худал мэдээллийг илүү бодит мэт, илүү үр нөлөөтэй байдлаар түгээх боломжийг бүрдүүлж байна.

Синтетик мэдээллийн манипуляцийн механизм нь хэд хэдэн үе шаттайгаар илэрдэг. Нэгдүгээрт, хиймэл оюун ухааны тусламжтайгаар бодит мэт контент үүсгэгдэнэ. Хоёрдугаарт, уг контент нь сошиал медиа платформуудын алгоритмаар дамжин өргөн хүрээнд тархана. Гуравдугаарт, хэрэглэгчид тухайн контентыг хүлээн авч, түүний үнэн бодит байдлыг шүүмжлэлгүйгээр хүлээн авах хандлагатай байдаг. Эцэст нь, энэхүү үйл явц нь олон нийтийн ойлголт, итгэлцэл, улмаар улс төрийн шийдвэр гаргалтад нөлөөлдөг. Ялангуяа алгоритмд суурилсан платформууд нь синтетик мэдээллийн тархалтыг эрчимжүүлэх чухал хүчин зүйл болж байна. Алгоритм нь хэрэглэгчийн сонирхол, өмнөх үйлдэлд тулгуурлан контентыг шүүж, анхаарал татахуйц, сэтгэл хөдлөл өдөөх контентыг илүү өргөн хүрээнд түгээх хандлагатай. Энэ нь синтетик мэдээлэл, тэр дундаа deepfake контентыг хурдан тархах нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн синтетик мэдээлэл нь “post-truth” буюу үнэний дараах орчныг бэхжүүлэхэд нөлөөлж байна. Энэ нь мэдээллийн үнэн бодит байдал биш, харин тухайн контентын сэтгэл хөдлөлд нөлөөлөх чадвар илүү чухал болох хандлагыг илэрхийлдэг. Ийм нөхцөлд хэрэглэгчид мэдээллийг үнэн эсэхээс илүүтэй өөрийн итгэл үнэмшилтэй нийцэж байгаа эсэхээр үнэлэх хандлагатай болдог.

Deepfake технологи нь улс төрийн манипуляцийн шинэ хэлбэрийг бий болгож байна (Westerlund, 2019). Улс төрийн этгээдийн нэр хүндэд халдах, худал мэдэгдэл хийсэн мэт харагдуулах, олон нийтийн санаа бодлыг төөрөгдүүлэх зэрэг зорилгоор ашиглагдах боломжтой. Энэ нь сонгуулийн үйл явц, ардчиллын чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Синтетик мэдээллийн өөр нэг онцлог нь түүний тархалтын хурд, цар хүрээ юм. Сошиал медиа орчинд нэг контент богино хугацаанд олон мянган хэрэглэгчид хүрэх боломжтой бөгөөд алгоритмын дэмжлэгтэйгээр viral хэлбэрээр тархдаг. Энэ нь мэдээллийн нөлөөллийг улам нэмэгдүүлдэг. Гэсэн хэдий ч синтетик мэдээллийг зөвхөн сөрөг үзэгдэл

гэж үзэх боломжгүй. Боловсрол, медиа үйлдвэрлэл, бүтээлч салбарт эерэг хэрэглээтэй байж болох боловч улс төрийн орчинд ашиглагдах үед түүний эрсдэл илүү өндөрсдөг. Иймээс синтетик мэдээлэл нь зөвхөн технологийн шинэчлэл бус, харин мэдээллийн манипуляцийн шинэ шатанд шилжсэнийг илэрхийлж байна. Deepfake болон “cheap fake” контент нь аудио, визуал мэдээллийг манипуляцлах шинэ хэлбэр болж байгааг судлаачид онцолсон (Paris & Donovan, 2019). Энэ нь олон нийтийн мэдээлэл хүлээн авах үйл явц, итгэлцлийн бүтэц, улс төрийн коммуникацийн онолын ойлголтыг дахин авч үзэх шаардлагыг бий болгож байна.

Судлагдсан байдлын тойм: Синтетик мэдээлэл, тэр дундаа deepfake технологийн хөгжил нь сүүлийн жилүүдэд эрдэм шинжилгээний судалгаанд өргөнөөр анхаарал татаж, улс төрийн мэдээлэл, харилцаанд үзүүлэх нөлөөллийг олон өнцгөөс авч үзэх болсон. Энэхүү хэсэгт олон улсын болон Монголын судалгааны чиг хандлага, гол үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэнэ. Олон улсын түвшинд хиймэл оюун ухаанд суурилсан мэдээллийн судалгаа нь технологийн хөгжилтэй уялдан хурдацтай өргөжиж байна. Чесни, Сайтрон нар deepfake технологийг “ардчилалд заналхийлж болзошгүй шинэ төрлийн мэдээллийн зэвсэг” гэж тодорхойлсон бөгөөд бодит мэт харагдах худал контент нь олон нийтийн итгэлцлийг алдагдуулах эрсдэлтэйг онцолсон. Тэдний судалгаанд deepfake нь зөвхөн худал мэдээлэл тараах хэрэгсэл бус, харин үнэн мэдээлэлд ч эргэлзээ төрүүлэх (“liar’s dividend”) нөхцөлийг бүрдүүлдэг гэж үзсэн байдаг.

Ваккари, Чадвик (2020) нарын судалгаанд deepfake контент нь хэрэглэгчдийн мэдээлэлд итгэх итгэлд сөргөөр нөлөөлөхөөс гадна улс төрийн мэдээллийг ялган таних чадварыг бууруулдаг болохыг тогтоосон. Тэдний туршилтын судалгаагаар deepfake видеог үзсэн оролцогчид тухайн мэдээллийн үнэн эсэхэд эргэлзэх хандлага өндөр байсан нь мэдээллийн орчны итгэлцлийн хямралыг илтгэж байна. Синтетик медиа нь “манипуляцийн экосистем”-ийн нэг хэсэг болж байгааг онцолж, технологи, платформ, хэрэглэгчийн зан төлөв гурвын харилцан үйлчлэлээр мэдээллийн нөлөөлөл бий болдог гэж үзсэн. Энэ нь синтетик мэдээллийг зөвхөн технологийн асуудал бус, харин нийгмийн бүтэц, медиа экосистемийн хүрээнд авч үзэх шаардлагатайг харуулж байна. Вэстэрланд (2019) хиймэл оюун ухаанд суурилсан медиа нь мэдээллийн үйлдвэрлэлийг автоматжуулж, контент бүтээх үйл явцыг хялбаршуулж байгааг онцолсон. Гэвч энэ нь худал мэдээлэл үүсгэх босгыг бууруулж, мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж дүгнэсэн.

Сошиал медиа платформуудын алгоритм нь мэдээллийн урсгалыг хянах шинэ “gatekeeper” болж байгааг тодорхойлсон. Энэ нь уламжлалт хэвлэл мэдээллийн үүргийг алгоритм орлож, ямар мэдээлэл олон нийтэд

хүрэхийг технологи шийдэх болсон нөхцөл байдлыг илэрхийлж байна. Синтетик мэдээллийн улс төрийн нөлөөллийг судалсан судалгаанд deepfake технологи нь сонгуулийн үйл явцад нөлөөлөх, нэр дэвшигчдийн нэр хүндэд халдах, олон нийтийн санаа бодлыг төөрөгдүүлэх эрсдэлтэйг онцолсон. Энэ нь ардчиллын чанарт сөргөөр нөлөөлөх боломжтойг олон судлаач тэмдэглэсэн.

Монгол Улсын хувьд мэдээллийн орчин, социал медиа хэрэглээтэй холбоотой судалгаа харьцангуй хийгдсэн боловч хиймэл оюун ухаанд суурилсан синтетик мэдээллийн чиглэлд судалгаа хомс хэвээр байна. Монголын судлаачид ихэвчлэн худал мэдээлэл, цахим орчны хэрэглээ, медиа боловсролын асуудлыг судалсан байдаг. Жишээлбэл, Монголын медиа орчны судалгаанд социал медиа нь мэдээллийн гол эх сурвалж болж, хэрэглэгчид мэдээллийг шалгалгүй хүлээн авах хандлага түгээмэл байгааг онцолсон. Энэ нь синтетик мэдээлэл тархах таатай орчин бүрдүүлж байгааг илтгэнэ. Мөн судлаачид мэдээллийн боловсрол (media literacy) сул байгааг тэмдэглэж, хэрэглэгчид мэдээллийн үнэн бодит байдлыг ялган таних чадвар хангалтгүй байгааг дурдсан. Монголын судалгааны хүрээнд хиймэл оюун ухаанд суурилсан синтетик мэдээлэл, deepfake технологийн нийгэм, улс төрд үзүүлэх нөлөөллийг авч үзсэн судалгаанууд сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Тухайлбал, Б.Чинзориг (2024) синтетик медиа болон deepfake контент нь Generative Adversarial Networks (GANs)-д суурилан бодит мэт аудио, визуал контент бүтээх боломжийг олгож, улмаар худал мэдээллийн шинэ хэлбэрийг бий болгож байгааг онцолсон. Тэрээр ийм төрлийн контент нь бодит ба худал мэдээллийн зааг ялгааг бүдгэрүүлж, цаашлаад “мэдээллийн сүйрэл” (infocalypse) үүсгэх эрсдэлтэйг дурдсан. Үүнийг системийн түвшинд тайлбарласан судалгаанд Б.Болормаа (2025) цахим орчин дахь худал мэдээллийг зөвхөн агуулгын асуудал бус, харин мэдээллийн үүсэлт, түгээлт, хүлээн авалтыг хамарсан “системийн асуудал” гэж үзэх шаардлагатайг онцолсон. Тэрээр цахим платформуудыг “саармаг дамжуулагч” бус, харин алгоритмаар дамжуулан контентыг эрэмбэлж, олон нийтийн ойлголт, итгэлцэлд идэвхтэй нөлөөлдөг субъект гэж тодорхойлсон (Б.Болормаа, 2025). Харин Б.Наранбаатар, Б.Намуун (2024) нарын судалгаанд deepfake технологийн Монгол дахь бодит нөлөөг олон нийтийн санаа бодлын судалгаанд тулгуурлан авч үзсэн бөгөөд оролцогчдын 69 хувь нь уг технологийн талаар мэдлэггүй, 80 хувь нь ийм төрлийн контент нь улс төрчдөд итгэх итгэлийг бууруулна гэж үзсэн нь мэдээллийн боловсролын түвшин сул байгааг илтгэж байна. Мөн тус судалгаанд төрийн өндөр албан тушаалтнуудын дүр, дуу хоолойг дуурайлган бүтээсэн deepfake контент Монголын цахим орчинд тархсан бодит кейсүүдийг дурдсан нь синтетик мэдээлэл аль хэдийн практик түвшинд нэвтэрснийг харуулж байна (Наранбаатар & Намуун, 2024).

Эдгээр судалгааг нэгтгэн үзвэл синтетик мэдээлэл нь зөвхөн технологийн дэвшлийн үр дагавар бус, харин алгоритмд суурилсан мэдээллийн орчин, олон нийтийн мэдээлэл хүлээн авах чадвар, улс төрийн итгэлцэл зэрэг олон хүчин зүйлсийн огтлолцолд үүсэж буй цогц үзэгдэл болох нь харагдаж байна. Гэсэн хэдий ч Монголын судалгаанууд нь ихэвчлэн тус тусдаа технологи, мэдээллийн орчин, эсвэл олон нийтийн хандлагыг авч үзсэн бөгөөд эдгээрийг улс төрийн мэдээлэл харилцааны хүрээнд нэгтгэн судалсан ажил харьцангуй хомс байна. Иймээс энэхүү судалгаа нь синтетик мэдээллийн онол, олон улсын судалгааны үр дүнг Монголын нөхцөлтэй уялдуулан авч үзэх, цаашид эмпирик судалгааны үндэс суурийг тавихад чиглэж байна.

Дүгнэж хэлбэл, олон улсын судалгаанд синтетик мэдээлэл нь мэдээллийн орчны итгэлцэлд заналхийлж (Chesney & Citron, 2019), улс төрийн коммуникацийн шинэ сорилтыг бий болгож байгааг харуулж байгаа бол Монгол Улсад энэ чиглэлийн судалгаа харьцангуй хөгжөөгүй, судалгааны хоосон орон зай их байгааг энэхүү тойм харуулж байна.

Синтетик мэдээлэл ба эрхзүйн зохицуулалтын шинжилгээ. Хиймэл оюун ухаанд суурилсан синтетик мэдээллийн тархалт нь зөвхөн технологийн бус, эрх зүйн шинэ сорилтуудыг бий болгож байна. Синтетик мэдээлэл, тэр дундаа deepfake контент нь хувь хүний эрх, мэдээллийн үнэн бодит байдал, улс төрийн шударга өрсөлдөөнд нөлөөлөх боломжтой тул эрх зүйн зохицуулалтын хүрээнд авч үзэх шаардлагатай. Олон улсын түвшинд синтетик мэдээллийг зохицуулах оролдлого идэвхжиж байгаа бөгөөд зарим улс орнууд deepfake контентыг тодорхойлох, тэмдэглэх, хориглох чиглэлээр хууль тогтоомж боловсруулж эхэлсэн. Жишээлбэл, Европын Холбоо хиймэл оюун ухааныг эрсдэлд суурилсан ангиллаар зохицуулах бодлого баримталж, өндөр эрсдэлтэй AI системд илүү хатуу шаардлага тавих хандлагатай байна. Мөн АНУ-д deepfake технологийг сонгуулийн үйл явцад ашиглахтай холбоотой зохицуулалтын асуудал идэвхтэй хэлэлцэгдэж байна.

Монгол Улсын хувьд синтетик мэдээллийг шууд зохицуулсан тусгай хууль байхгүй боловч холбогдох зарим хууль тогтоомжид тусгагдсан заалтуудыг өргөтгөн тайлбарлах замаар хэрэглэх боломжтой байна. Үүнд хувь хүний мэдээлэл хамгаалах, харилцаа холбоо, эрүүгийн эрх зүй, сонгуулийн болон кибер аюулгүй байдлын зохицуулалтууд хамаарна. Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль нь мэдээллийг зөвшөөрөлтэйгээр ашиглах үндсэн зарчмыг тогтоосон. Энэ нь deepfake технологиор хүний дүр төрх, дуу хоолойг зөвшөөрөлгүйгээр ашиглах асуудалтай шууд холбогдох боломжтой. Гэсэн хэдий ч уг хууль нь “хиймэл контент” гэсэн ойлголтыг тусгайлан тодорхойлоогүй бөгөөд бодит болон синтетик мэдээллийн ялгааг

тодорхойлох асуудал тодорхойгүй хэвээр байна.

Харилцаа холбооны тухай хуульд үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон бөгөөд платформууд контентыг хязгаарлах боломжтой боловч алгоритмд суурилсан контент түгээлтийн бодит практиктай тодорхой зөрчил үүсэх боломжтой. Ялангуяа ялгаварлахгүй үйлчилгээ үзүүлэх зарчим нь алгоритмын шүүлтүүртэй зөрчилдөж болзошгүй юм. Эрүүгийн хуульд зөвшөөрөлгүй бичлэг тараах, хувь хүний нууц задруулах, худал мэдээлэл тараах зэрэг заалтууд синтетик мэдээлэлтэй холбогдох боломжтой. Гэвч эдгээр зохицуулалтууд нь уламжлалт гэмт хэргийн хэлбэрт чиглэсэн бөгөөд deepfake зэрэг хиймэл контентын онцлогийг бүрэн тусгаагүй байна. Мөн худал мэдээлэлтэй холбоотой зарим заалтын хэрэгжилт сул байгаа нь эрх зүйн үр нөлөөг бууруулж байна.

Сонгуулийн тухай хуульд сонгуулийн үеийн худал мэдээлэл, манипуляцийг хязгаарлах зохицуулалт тусгагдсан боловч AI ашиглан хиймэл контент үүсгэх, олон нийтийн санал бодлыг хиймлээр бүрдүүлэх зэрэг шинэ хэлбэрийн нөлөөллийг тусгайлан зохицуулаагүй байна. Энэ нь сонгуулийн шударга байдалд шинэ эрсдэл үүсгэж болзошгүй. Кибер аюулгүй байдлын тухай хууль нь мэдээллийн системийн хамгаалалт, аудит, эрсдэлийн үнэлгээнд төвлөрсөн бөгөөд “инфраструктурын аюулгүй байдал”-ыг хангахад чиглэсэн. Гэвч синтетик мэдээлэл нь “контентийн аюулгүй байдал”-тай холбоотой асуудал тул уг хуульд бүрэн хамрагдахгүй байна.

Эдгээрээс дүгнэхэд Монгол Улсын эрх зүйн орчин нь синтетик мэдээллийг шууд зохицуулах бус, харин уламжлалт зохицуулалтыг өргөтгөн тайлбарлах түвшинд байна. Энэ нь дараах гол сул талуудыг илэрхийлж байна:

- Нэгдүгээрт, синтетик мэдээллийн тодорхойлолт, ангилал эрх зүйн түвшинд байхгүй байна.
- Хоёрдугаарт, deepfake контентыг илрүүлэх, тэмдэглэх, хянах механизм тодорхойгүй байна.
- Гуравдугаарт, алгоритмд суурилсан мэдээллийн тархалтыг зохицуулах бодлого сул байна.
- Дөрөвдүгээрт, сонгуулийн орчин дахь AI хэрэглээг тусгайлан зохицуулаагүй байна.

Иймээс цаашид синтетик мэдээллийг зохицуулахдаа дараах чиглэлд анхаарах шаардлагатай. Үүнд: хиймэл оюун ухаанд суурилсан контентыг тодорхойлох эрх зүйн ойлголт бий болгох, deepfake контентыг ил тод болгох (labeling) механизмыг нэвтрүүлэх, платформуудын хариуцлагыг

тодорхой болгох, мөн сонгуулийн орчинд AI ашиглахтай холбоотой тусгай зохицуулалт боловсруулах зэрэг орно. Ийм зохицуулалт нь зөвхөн хориглох бус, харин урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангах, хэрэглэгчдийн мэдээллийн боловсролыг нэмэгдүүлэхтэй уялдах шаардлагатай. Энэ нь синтетик мэдээллийн эрсдэлийг бууруулахад илүү үр дүнтэй байх болно.

Дүгнэж хэлбэл, синтетик мэдээлэл нь эрх зүйн уламжлалт ойлголтуудыг сорьж, шинэ зохицуулалтын хэрэгцээг бий болгож байгаа бөгөөд Монгол Улсад энэ чиглэлийн бодлого, эрх зүйн орчныг хөгжүүлэх шаардлага бодитойгоор тулгарч байна. Ялангуяа deepfake контентыг заавал тэмдэглэх (mandatory labeling) болон платформын хариуцлагыг хуульчлах нь нэн тэргүүний шаардлага болж байна.

Дүгнэлт. Энэхүү тойм өгүүлэлд хиймэл оюун ухаанд суурилсан синтетик мэдээлэл нь улс төрийн мэдээлэл, харилцаанд үзүүлэх нөлөөг онолын болон эрх зүйн хүрээнд авч үзлээ. Судалгааны үр дүнгээс харахад синтетик мэдээлэл нь уламжлалт худал мэдээллээс чанарын хувьд ялгаатай, илүү өндөр итгэл төрүүлэх чадвартай, алгоритмд суурилан өргөн хүрээнд хурдан тархах онцлогтой болох нь тогтоогдож байна. Улс төрийн мэдээлэл, харилцааны уламжлалт онолууд болох сэдэв тогтоох, мэдээллийн хүрээ тогтоох, урьдчилсан нөлөөллийн онолууд нь синтетик мэдээллийн орчинд шинэчлэн тайлбарлагдах шаардлагатай болж байна. Учир нь мэдээллийн урсгалыг зөвхөн хэвлэл мэдээлэл бус, алгоритм болон хиймэл оюун ухаан тодорхойлох болсон нь мэдээллийн нөлөөллийн механизмыг өөрчилж байна.

Синтетик мэдээлэл нь мэдээллийн манипуляцийн шинэ шатанд шилжсэнийг илэрхийлж байгаа бөгөөд бодит мэт контент үүсгэх чадвар нь хэрэглэгчдийн шүүмжлэлтэй сэтгэлгээг сулруулж, мэдээлэлд итгэх итгэлд нөлөөлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Ялангуяа deepfake технологи нь улс төрийн орчинд ашиглагдах үед нэр хүндэд халдах, худал мэдээлэл тараах, олон нийтийн ойлголтыг төөрөгдүүлэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй. Эрх зүйн зохицуулалтын хувьд Монгол Улсад синтетик мэдээллийг шууд зохицуулсан тусгай хууль байхгүй боловч холбогдох хууль тогтоомжууд тодорхой хэмжээнд хамаарах боломжтой байна. Гэсэн хэдий ч эдгээр зохицуулалтууд нь уламжлалт мэдээллийн орчинд төвлөрсөн бөгөөд хиймэл оюун ухаанд суурилсан контентын онцлогийг бүрэн тусгаагүй байгаа нь судалгаагаар тогтоогдлоо. Иймээс синтетик мэдээллийн эрсдэлийг бууруулахад дараах бодлогын чиглэлүүдийг санал болгож байна. Үүнд: хиймэл оюун ухаанд суурилсан контентыг тодорхойлох, ангилах эрх зүйн ойлголтыг бий болгох; deepfake контентыг ил тод болгох, тэмдэглэх механизмыг нэвтрүүлэх; сошиал медиа платформуудын хариуцлагыг нэмэгдүүлэх; сонгуулийн орчин дахь AI хэрэглээг тусгайлан зохицуулах;

мөн хэрэглэгчдийн мэдээллийн боловсролыг сайжруулах зэрэг орно.

Хэлэлцүүлгийн хүрээнд синтетик мэдээллийг зөвхөн сөрөг үзэгдэл гэж үзэхээс илүүтэй түүний эерэг болон сөрөг нөлөөллийг тэнцвэртэй авч үзэх шаардлагатай. Хиймэл оюун ухаан нь мэдээлэл үйлдвэрлэл, бүтээлч салбарт шинэ боломжуудыг бий болгож байгаа боловч улс төрийн орчинд ашиглагдах үед өндөр эрсдэл дагуулж байна. Иймээс синтетик мэдээлэл нь орчин үеийн улс төрийн коммуникацийн “шинэ эрсдэлийн архитектур”-ыг бүрдүүлж байна.

Цаашид энэхүү чиглэлд Монголын нөхцөлд суурилсан эмпирик судалгаа хийх, хэрэглэгчдийн синтетик мэдээллийг хүлээн авах байдал, итгэлцэл, ялган таних чадварыг судлах нь чухал ач холбогдолтой юм. Энэ нь синтетик мэдээллийн нөлөөллийг илүү бодитой үнэлэх, зохицуулалтын үр нөлөөг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

Олон улсын судалгааны бүтээл

Chesney, R., & Citron, D. (2019). *Deepfakes and the new disinformation war*. *Foreign Affairs*, 98(1), 147–155.

Entman, R. M. (1993). *Framing: Toward clarification of a fractured paradigm*. *Journal of Communication*, 43(4), 51–58.

Iyengar, S., & Kinder, D. R. (1987). *News that matters: Television and American opinion*. University of Chicago Press.

Klinger, U., & Svensson, J. (2018). *The end of media logics? On algorithms and agency*. *New Media & Society*, 20(12), 4653–4670.

McCombs, M., & Shaw, D. (1972). *The agenda-setting function of mass media*. *Public Opinion Quarterly*, 36(2), 176–187.

Paris, B., & Donovan, J. (2019). *Deepfakes and cheap fakes: The manipulation of audio and visual evidence*. Data & Society Research Institute.

Vaccari, C., & Chadwick, A. (2020). *Deepfakes and disinformation: Exploring the impact of synthetic political video on deception, uncertainty, and trust in news*. *Social Media + Society*, 6(1).

Westerlund, M. (2019). *The emergence of deepfake technology: A review*. *Technology Innovation Management Review*, 9(11), 40–53.

European Commission. (2021). *Proposal for a regulation laying down harmonised rules on artificial intelligence (Artificial Intelligence Act)*.

Монгол судлаачдын бүтээл

Чинзориг, Б. (2024). Медиа мэдээллийн шинэ хэрэгсэл дэх синтетик медиа буюу гүн худал (synthetic media-deepfake) мэдээллийн асуудалд. *Mongolian Journal of Humanities and Social Sciences*, 9(18). <https://doi.org/10.69542/mjhss.v9i18.3697>

Болормаа, Б. (2025). Цахим орчин дахь худал мэдээллийн зохицуулалт, чиг хандлага. “Сэтгүүл зүй”, №26, 135–148.

Наранбаатар, Б., & Намуун, Б. (2024). Хиймэл оюунаар бүтээсэн синтетик мэдээлэл олон нийтийн итгэлд нөлөөлөх нь. “Сэтгүүл зүй”, №25.

Хууль, эрх зүйн эх сурвалж

Монгол Улсын Их Хурал. (1992). *Монгол Улсын Үндсэн хууль*. <https://legalinfo.mn>

Монгол Улсын Их Хурал. (2015). *Эрүүгийн хууль*. <https://legalinfo.mn>

Монгол Улсын Их Хурал. (2021). *Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль*. <https://legalinfo.mn>

Монгол Улсын Их Хурал. (2021). *Кибер аюулгүй байдлын тухай хууль*. <https://legalinfo.mn>

Монгол Улсын Их Хурал. (2001). *Харилцаа холбооны тухай хууль*. <https://legalinfo.mn>

Summary

This review article examines the impact of AI-based synthetic media, particularly deepfake technology, on political communication. The study explores theoretical frameworks, including agenda-setting, framing, and priming, in the context of algorithm-driven media environments. It also analyzes the mechanisms of information manipulation enabled by synthetic media and reviews the current legal framework in Mongolia. The findings indicate that synthetic media significantly transforms information ecosystems by increasing the realism, speed, and reach of manipulated content. While existing legal frameworks partially address related issues, they do not adequately cover the specific characteristics of AI-generated content. The study highlights the need for updated regulatory approaches, including content labeling, platform accountability, and policy reforms tailored to emerging technologies.

Keywords: synthetic media, deepfake, artificial intelligence, political communication, information manipulation, regulation